

### ӨРНӨДИЙН ЗАГВАРЫГ ӨӨРИЙМШҮҮЛЖ ЧАДСАН СЭТГҮҮЛЧ

Л.Норовсүрэн\*

\* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)

**Түлхүүр үг:** ур чадвар, олигархжсан нам, сурвалжлага, улс төр, талцал, мэргэжлийн сэтгүүлч, итгэлцэл, онолын үндэс, уламжлал

Өнгөрсөн зууны наядад онд «Октябрьийн туяа» гэдэг сэтгүүл гардаг байв. Тэр сэтгүүлийн бичлэг манайхныхаас нэг л өөр, юмыг шууд хэлдэг, товч өгүүлбэрээр санаагаа оновчтой гаргадаг онцлогтой байлаа. Тухайн үед би тийм бичлэгийг орчуулгын нөлөө байх гэж боддог байсан юм. Одоо бодоход уран зохиолын нөлөөнд хэт автсан манай сэтгүүл зүйн туурвилаас ялгараах онцлог нь байсан юм билээ. Өөрөөр хэлбэл нийтлэлийн хэл найруулга бие даан төлөвшөний илрэл байжээ.

Улс орон ардчилсан тогтолцоонд шилжсэн ерээд оноос уламжлалт сэтгүүл зүйн олон арга барил шинэчлэгдсэний дотор бичлэгийн төрөл зүйлд огцом өөрчлөлт гарсан юм. Түүнийг өрөнхийд нь уналт, өөрчлөлт, сэргэлт хэмээн томьёолж болох бөгөөд “өөрчлөлт” гэдэг нийтлэлийг “Адамаас эхэлж” бичдэг хуучин барилыг халж, үйл явдлын өрнөл, үр дүнгээр толгойлж бичдэг аргад шилжсэн үйл явцыг ойлгож болно. Тийм хөнгөн,

товч, оновчтой, бас сонирхолтой бичлэгийг монгол хөрсөнд идээшүүлж чадсан сэтгүүлчийн нэг нь Лунтангийн Болормаа юм. «Даашиinzтай сурвалжлагууд» (2007) номоороо Өрнөдийн сэтгүүл зүйн бичлэгийн аргыг үндэсний онцлогтойгоо яаж хослуулахын үлгэр жишээг үзүүлсэн тэрээр «...Бид маш их сэтгэлийн хөдөлгөөнтэй, тортон мэдрэмжтэй уншигчид зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Тэдэнд тоогдох материал нийлүүлэхийн тулд халуун үйл явдал руу ханцуй шамлан хүрэх зоригтой, зүрх сэтгэлийн утсыг хөндөн бичих ур дүйтэй, хажууханд харагдах нулимстай нүднээс баяр гунигийг нь тайлж унших мэдрэмжтэй»<sup>1</sup> байх хэрэгтэйг мэргэжил нэгтнүүддээ захицсан байдаг. Энэ нь уран зохиол шиг уянгалаад, урсгаад, уяруулаад бай гэсэн үг биш, харин үнэнийг зүрхэнд хүртэл хэлээд өг, юмны уг шалтгааныг ухаж төнхөөд, ухааруулж итгүүлээд өг гэсэн үг байж таарна.

Сэтгүүлч Л. Болормаа хэдэн жилийн өмнөөс гол төлөв нийгэм, улс төрийн тулгамдсан, хурц асуудал хөндж «Өнөөдөр» сонинд бичсэн логик дараалал сайтай товчон өгүүлбэрээс бүтсэн, хэрсүү санаатай нийтлэлүүдээрээ уншигчдын танил болсон билээ.

Тэр цагаас хойш бичсэн бүхэндээ заавал нэг часхийсэн санаа хэлдэг түүний нийтлэлийг сонини байнгын уншигчид дугаар бүхнээс нэхдэг болсон байх.

Л. Болормаа 1998 онд Монгол Улсын Их Сургуулийг сэтгүүлч мэргэжлээр төгсч, мөн оноо «Өнөөдөр» сонини Эдийн засаг, бизнесийн мэдээллийн албанад сурвалжлагч, тоймч, 2001 оноос өнөөг хүртэл тус сонини орлогч эрхлэгчээр ажиллаж байна. Тэрээр зарим хүний адил сонини "тогоо"-нд удаан чанагдсангүй, халуун "шөл"-нд дөнгөг дүрэгдмэгцээ л "болчихсон" нь мэргэжилтнүүдийн анхаарлыг татсан юм<sup>2</sup>.

Л. Болормаагийн нийтлэл сэдвийн өргөн хүрээтэн дээр өгүүлэл, сурвалжлага, ярилцлага, тэмдэглэл зэрэг олон төрөл, зүйлээр бичигдсэн байдаг. Тэрээр саяхан болтол орлогч эрхлэгчээр нь ажиллаж байсан «Өнөөдөр» сонинд цаг үеэ тусгасан хэдэн зуун нийтлэл бичсэний дотор «Хөрөнгийн зах зээлийн парадокс» (1999. №102), «Олигархжсан намууд» (2005. №248), «Өрсөлдөөн» (1999. №120), «Хятадын түрлэг» (2005. №230), «Монголчууд хий "түлж" буузаа жигнэнэ» (2000. №295), «Банкны "мафиас" хэтэвчтэй хэдийнхээ чансааг асууя» (2005. №65), «6436 зээлдэгчийн тухай мэдээлэл бий» (1999. №9), «Монголын банкирууд юунаас айдаг вэ?» (2005. №272), «Дипломатын бизнес» (2000. №260), «Улс төрчдийн зуны даалгавар» (2005. №151), «Мөнгөний тухай ярих урлаг» (2001. №24), «Байцааг түшмэл» (2002. №129), «С. Огтонбаатар: Бид банкны увайгүй хүүлэл дор хөрөнгө оруулалт нэртэй зүйл хийх гэж оролдож явна» (2005. №238), «Цасан угалз» (2002. №290), «Вант улс үүрэндээ үймж эхлэв» (2004. №256), «Алт гялалзсан

өдрууд буюу Америк, Монголын адилхан зовлон» (2004. №278), «Ямаачин гадилд дургүй» (2003. №79), «Бэхжүү тэмээ ба Швейцарийн Монголчууд түүх» (2004. №2), «Нийслэлийн застийн газартай больё» (2004. №15), «Иракийн тэмдэглэл» (2004. №42), «Цовдуулсан Прометей» (2004. №292), «Чимээгүй аюул» (2004. №74), «Сангийн сайд бүтэн нойртой хонон тоо ба түүнээс улбаалах улстөржэвдлийн 2006 онд» (2005. №258), «Улс төрийн хүчин үнэн мэдээллээр түүнийг хэзээ ч хангадаггүй» (2005. №105) зэрэг өгүүлэл, ярилцлага, сурвалжлага, тэмдэглэлүүд нь сэтгүүлчийн ур чадварын өсөлтийг харуулсан сайн нийтлэл болсон юм.

**Л** Болормаа «Олигархжсан намууд» гэдэг өгүүлэлдээ Монголын улс төрийн намууд үзлэх болдолдоо тулгуурлан ажиллахад больж, эдийн засгийн бүлэглэлүүдэй гүнзгий орооццодож, эрх мэдэлтэн, бэлэнчинтэнгүүдийн хуйвалдааны үүр уурхай болсныг илчлэн шүүмжилжээ. Сэтгүүлч бий болсон нэхцэл байдлыг дүгнэж «Эдүгээ Монголын нийгмийг хэрэн торлоод байгаа хэрүүл зарга, үл ойлголцол, толхилцлын үүр, үндэс хөврөл нь намын навтгар цагаан байшингүүд болов. Уг нь тэдгээрт овоо том эрх ашгийг илэрхийлдэг уламжлал байсан. MAXN, Ардчилсан нам аль нь гишүүд дэмжигчдийнхээ итгэл үнэмшил дээр амьдарч, Монгол дахь улс төрийн шинэчлэл бусад үлгэржишээ болдог байв... Хэдийгээр эдийн засгийн салбарт шинэчлэл хоцорсон ч улс төрийн орчинд хүрсэн амжилт, ардчиллын ололтоо ам өрсөн зарлаагүй бил үү. Гэтэл УИХ-ын өнгөрөн сонгуулиас хойш үндэсний байтугай

«Сэтгүүл зүй» МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг, 2014 он, №15

ядаад намын эрх ашгийн тухай ярихаа байж. Талцал, хуваагдал улам явцуураа лаа "хэмээн бичсэн байна.

Тэрээр намын эрх мэдэлтнүүдийн талцал, хуваагдал нь төрийн бодлого тодорхойлоход нэлэөлж байгааг «Хуулийн төслийн мөн чанарыг ухаж ойлох, ажил хэрэгч санал дэвшүүлэх, бие даасан эрүүл саруул байр суурь илэрхийлэх гишүүн чуулганы танхимд нэн ховорджээ. Төрийн хүнийг зутгуулэх, унацтай ар тал бүрдүүлэх марафонд УИХ-ын гишүүд уухайлсан хэвээр. Сүүлдээ уралдаан тэмцээн намын харьятууд дунд бус, бяцхан бүлэглэлүүдийн дунд эрчимтэй өрнөж байна. Тэр компанийн гэх тодотгол бөх, хулэг морь, улс төрч гурвины чансааг илэрхийлж эхэллээ» гэж нүдийг нь олж хэлжээ.

Л. Болормаа нам, төрийн хямрал, гажуудал эргээд улс орны хөгжлийг гацаанд оруулж, олон улсын итгэлийг супруулж байгааг оновчтой тодорхойлсон байна. Тухайлбал «Улс төрийн салбарт хэдхэн жилийн өмнө хамаагүй их ололт дэвшил үүрч, дүүрч явсан Монголчууд ийнхүү оросуудаас хоёр алхам хоцров. Хөгжил дэвшил ухрах араандаа орсныг гэрчлэх гунигт баримтууд сонсогдоор. Аль хоёр жилийн өмнөөс Мянганы сорилын сангаас 270 сая орчим ам. доллар авахаар бид хөөцөлдсөн. Тэгвэл энэ мөнгөний чимээ улам холдов. Эцэст нь «Улс төр, бизнесийн эрх ашгаас ангид» төслийг америкичуд биднээс дахин нэхсэн юм. АНУ-ын Элчин сайд П. Слуц Монголд авилга газар авч буйг саяхан сануулжээ» гэсэн байна.

Л. Болормаа өгүүллийнхээ төгсгөлд «Улс төр, бизнесийн сүлбээ нийгмийг улам бур дархлаагүй болгож байна. Улмаар олигархууд өөрсдийгөө хамгаалах хүчиний үнэнч байгууллага, төлөө-

ний түшмэлтэй болцгоохор улайран зүтгэв. Шүүх, цагдаа тойрсон томилгоо, халаа сэлгээ энэ оны сүүлийн хагаст эрчимжиж, эргэн тойронд нь «Энэ чинь хэндийн хүн бэ?» гэх асуулт ямагт дагалдах аж. Төрийн өмчийн хороо, цагдаа, шүүх зэрэг бусармаг санаагаа гардан гүйцэтгүүлдэг «анхан шатны нэгж» дэх томилгоо анхаарлын төвд байхаас яхав. Аль нэг бүлэглэлийн нөөлөгт багтаагүй бол чи хэн ч биш болох цөвүүн цаг гэж нэрлэмээр санагдана... Намын байруудад соёолсон Монголын олигархийн үр хөврөл нийгмийн салаа мөчир бүрт савраа хүргэхээр айсүй. Сүүлдээ үнэт зүйл, үзэл бодлын ялгарал ч падгүй болж, зөвхөн мөнгөний ард нам мам гэлгүй найрлахаар зэхэв.

Намаа худалдах, намаас нэр дэвшигчийг жийх, намгүй зөвшилцэх хувийн тогтолц бүрийг олигархийн эргүүлэг хаман авч байна. Энэ хар эргүүлэг дор хэний зөв, юу нь шударга болохыг ялгахыг оролдоно гэдэг зангууны үлгэртэй ойролцоо» хэмээн бичсэн байна. Сэтгүүл зүйн онолын үүднээс энэ өгүүллийг баримт нотолгоогүй хэмээн өөлж болох авч давхар давхар хуягаар халхалж хамгаалуулсан бусармаг улс төрийн хөшигний цаана нэвтрэх бололцоо, эрх зүйн орчин Монголд үгүй юм. Иймд бүхний нүдний өмнө болоод байгаа үнэнийг мэдрэмжээрээ үнэлж дүгнэхэд хүрдэг нь сэтгүүлчдийн буруу биш билээ.

**С** этгэлгээ цэгцтэй байх нь уг хэл цэгцтэй байхын үндэс болдог. Энэ үндэслэлээр авч үзвэл Л. Болормааг чамгүй ихиг үншиж оюун ухаанаа задалсан, бодол санаагаа эмх цэгцтэй илэрхийлэх аргад суралцсан, мэргэжлийн сэтгүүлчид тавигдах наад захиын хэм хэмжээг мөрдэж заншсан чадварлаг сэтгүүлч гэж үнэлмээр

байдаг. Ийм шилдэг чанарын илрэлийг «Улс төрчдийн зуны даалгавар» гэдэг нийтлэлээс нь харж болох юм.

Л. Болормаа ерөнхийдөө улс төрийн прогнозын шинжтэй энэ өгүүлээ «Даалгавар 1: 65 дугаар тойрог», «Даалгавар 2: Засгийн газрын хувь заяа», «Даалгавар 3: 62-ын булаг», «Даалгавар 4: 24 дүгээр тойрог», «Даалгавар 5: УИХ-ын дарга, шинэ ерөнхий сайд», «Даалгавар 6: Том томилгоонууд» гэсэн зургаан хэсэгт төвлөрүүлэн бичсэн нь ч түүний цэгтэй сэтгэлгээ, эрэмбэлтэй өгүүлэлжийн үндэс болжээ. Энэ бүтэц нь УИХ-ын 65 дугаар тойргийн нөхөн сонгуулийн дараа улс төрийн хүрээнд гарч болох зөрэг ба сөрөг олон хувилбаруудыг урьдчилан таамаглахыг эрмэлзсэн зохиогчийн зорилгод гойд нийцэж байна. Өөрөөр хэлбэл “нэг хувилбар-нэг дэд сэдэв” гэсэн зохиомжийг сонгосон байна. Нэг зүйлийг тэмдэглэхэд уг өгүүлэлд зориулж хийсэн зураасан зургийн нийтлэл өгүүллийнхээ агуулга, шинж чанарт тохирсонгүй. Бие даасан утга бүхий зураасан зургийн нийтлэлийг хүчээр зүүсэн мэт болсныг тэмдэглүүштэй. Харин өгүүллийн хувьд өөлөх юм алга.

**С**этгүүлч, өгүүллийнхээ эхэнд УИХ-ын нөхөн сонгуулийн 65 дугаар тойрог нь «Бараг “үеийн үед” МАХН-ын нэр дэвшигчийг дэмждэг онцлогтой өндөрлөг гэнэ дээ. III, IV хорооллын дэнж дээр энэ удаа Ц. Элбэгдорж өөр зугийн салхи дэгдэж болзошгүй нь. М. Энхболдын нойрмогдуу харцанд оч цог нэмэхгүй бол гялалзуур Ерөнхий сайдад МАХН 65 дугаар тойргийг алдаж иedmээр таамаг буугаад байх шиг. Жижиг намуудын хувьд дэмий амбиццаж явахаар Ц. Элбэгдоржийг дэмжихээ зарлаачихвал энд бодитой өрсөлдөөн болж мэдэх

юм» хэмээн таамагласан бол, удаа хэсэгт «Нэхөн сонгуульд Ц. Элбэгдоржийн нэрийг дэвшүүлсэн нь МАХН-ын тай ялаагүй... 65 дугаар тойргийн сонгууль болтол Монгол улс Засгийн газартай ч юм шиг, угүй ч юм шиг нэг хэсэгтээ гэлдрэх нь. УИХ-ын өнөрсөн жилийн сонгуулийн хөлд ард иргэд, улс орны амьдралын амин чухал асуудал мартагдсан шиг засаглалын хомдол энэ удаа давтагдах вий хэмээн олон нийт эмээж байна» гэжээ.

Л. Болормаа нөхөн сонгууль Засгийн газрын хувь заяанд хэрхэн нөлөөлөх талаар өөрийн бодлыг илэрхийлэхдээ «Засгийн газарт шийдэх асуудал чухал болохоос урт, богино нас гол зүйл биш хэмээн Ерөнхий сайд Европоос дөнгөж ирээд мэдэгдсэн ю. Үнэндээ тийм гэж үү? Итгэлцэл, ойлголцолгүйгээр Израйлийн туршлагыг Монголд хэрэгжүүлэх аргагүй шүү дээ. Танхим ирэх гурван жилийн баталгаат хугацаандаа итгэлтэй байж, нэг санаагаар хөдлөхгүй бол Ц. Элбэгдорж ганцаараа Хархорин руу зам тавиад. Ч. Сайханбилэг ухаалаг үнэмлэх тараагаад явах юм уу... 2004 оны есдүгээр сарын 21-ний баримт бичигт 18 сайдын бүрэн эрхийн хугацааг дөрвөн жил байхаар тохиролцжээ. Өмнөговийн дуулиан бусад аймагт халдвартлаад Ерөнхий сайд, Шадар сайд хоёр “хуулиас дээгүүр зөвшилцөл бий, угийдээ хүрч, зөвшилцлөөс дээгүүр хууль байх учиртай” хэмээн дахин муудалцах юм бол айсүй гурван жилийн уртыг давж туулахааргүй өөнтөгч танхим» хэмээн тодорхойлсон байна. Л. Болормаа өгүүлэл, нийтлэлдээ сэтгүүл зүйн бичлэгийн онолын уламжлалт тодорхойлолтыг төдий л их баримтлалдаггүй, олон зүйлийн зааг дээр нэлзэд чөлөөтэй бичиж туурвидаг

онцлог нь энэ өгүүлэлд ч харагдаж байна.

Тэрээр энгийн хүүрнэж, үйл явдлыг үнэлж дүгнэж байснаа гэнэт цахилгаан гялсхийн мэт сонин содон зураглал, шог хошин аястай өгүүлбэрийг сонгон хэрэглэж үншигчaa татдаг өвөрмөц барилтад сэтгүүлч юм. Тухайлбал «Даалгавар 4: 24 дүгээр тойрог» гэсэн хэсэгт «Монголд хэн жаргалтай вэ гэвэл Занданхүүгийн

Энхболд юуны түрүүнд

санаанд орох юм» гэж

“хэрэгт дуртай” үншигчийн хорхойг хүргээд, түүнийгээ тайлбарлаж «УИХ-ын жинхэнэ гишүүн мөн эсэхийг нь хэдэн шатны шүүх жил тойрон хээлцэж байх зуур Төрийн өмчийн хороог толгойлж, энэ

нийгмийг чоносон дуулиан шуугиантай баримтууд цацаад, түүнд ер уйдах, парламентын гишүүний үнэмлэх хүлээн цөхөрч суух зав зай алга. Мөнөөх л 65 дугаар тойргийн сонгуулийн дунг амдахаар түр тудгэлзүүлсэн гэх түүний “хэрэг” мөд шийдэгдэнэ гэдэгт эргэлзэхгүй байна» гэснийг жишигж болно.

Сэтгүүлч өгүүллийнхээ дараагийн хэсгүүдэд нөхөн сонгуульд МАХН ялсан нөхцөлд хэн хэндиг ямар ямар шинэ томилгоо хүлээж байгааг таамаглаад «Зуны зугаатай өдрийд үргэлжилж байна. Өнгөц хараад наадамдаж, найр хэссэн хүмүүс. Ирэх намрын их бужигнааны өмнө улс төрчид дор доороо даалгавар ихтэй, тооцоо төлөвлөгөөтэй амралтаа эхэллээ» хэмээн «Зуны даалгавар» гэсэн гарчгаа зангидал төгсгесэн байна.

Л. Болормаа нийтлэлийнхээ сэдвийг улс орны амин чухал үйл хэрэг, олон

нийтийн анхаарал татсан асуудлуудад чиглүүлж, хэрэг явдлын учир шалтгааныг илрүүлэн, чамбай санаа, дүгнэлт гаргаж бичдэг онцлогтой сэтгүүлч юм. Тэрбээр «Оюу толгойг дагасан олз, гарз» гэдэг нийтлэлдээ бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэх үедээ манай орны экспортын бүтээгдэхүүний хэмжээг түрав дахин есгэж, нийгэм-эдийн засгийн олон үзүүлэлтийг эрс сайжруулах тооцоотой «Оюу толгой» төслийн тухай бичихдээ хамгийн түрүүнд олзны хойноос гарз нүүрлэх аюулыг сэргэмжлүүлсэн байдаг. Уурхайг ажиллуулахад шаардагдах эрчим хүч, усны нөөцийг хэрхэн шийдвэрлэх асуудалд сэтгүүлч онцгой анхаарсан нь гол

гогцоо асуудлаа олж харсны илэрхийлэл мөн. «Оюу толгой» төслийг монголд илүү үр ашигтай байлагх талаар мэргэжилтнүүд олон санал гаргадаг. Сэтгүүлч тэр бүхнээс усны асуудалд ихээхэн санаа зовж байгаагаа илэрхийлж «Гүний ус нөхөн сэргээддэггүй. Тиймээс уурхайг ажиллуулахад шаардагдах их хэмжээний усны нөөцийн асуудал “Айвенхуу Майнз”-ын төдийгүй, монголчуудын анхаарлын төвд байгаа юм. Олзыг даган байгаль орчинд нөхөгдөшгүй гарз урчах вий...» гэжээ. «Айвенхуу Майнз» уурхайгаа ажиллуулах эхний таван жилд Өөвр Монголоос эрчим хүч авч, явцын дунд Таван толгойн нүүрсний уурхайн дэргэд шинэ цахилгаан станц барих бодлойт байгааг сэтгүүлч тэмдэглээд уурхайг эхнээс нь дотоодын эрчим хүчний эх үүсвэрээр

ажиллуулах Засгийн газрын байр суурийг хамгаалжээ. Эцэст нь «Оюу толгой»-н ордыг түшиглэн байгуулах уурхай нь үнэхээр Индонезийн Гразбергийн дараа дэлхийд хоёрдугаарт орох асар том ажил хэрэг мөн л юм бол эндээс монголчуудад унах өгөөжийг улам нэмэгдүүлэх ёстой» гэсэн байр сууриа илэрхийлсэн байна.

Л. Болормаа «Маргаашийн уушгинд мөнгө хүримтлуулъя» гэдэг өгүүлэлдээс манай улсын экспортын гол бүтээгдэхүүн зэс, алтын үнийн өсвөлтөөс шалтгаалан 2005 оны улсын төсвийн орлогоос 40 гаруй тэрбум төгрөг илүү гарсан тухай өгүүлээд уг мөнгийг оновчтой зарцуулахад өөрийн саналыг нэмэрлэсэн нь цаг үеэ олсон, үр нелөөтэй нийтлэл болжээ. Төсвийн орлогоос их хэмжээний мөнгө илүүдэснийг дуулаад гар тосох, хувааж авах санаархалд автагдахгүй байхыг улсын төсөв захирагч нарт анхааруулж «40 тэрбум төгрөгийн 30 нь зэсийн баяжмалын арилжаанаас орж ирсэн цэвэр ашиг. За одоо бүгдээрээ зад найрлацаагаа уу? Зургаан аймгийн засаг дарга оны шувтаргаар төсвийн тодотгол гүйц царай алдаад явсан. Тэдэнд мөнгө өгөөд, бас бус баахан “гал” унтрааж орхивол яах бол? Тэгвэл ийм өөх түгээдэг өмнөх өгөөмөр зангаас Сангийн сайд та шууд татгалзаарай. Ер нь бондгор гахайгаа яаран подхийлгэх хэрэггүй болохыг улс орнуудын туршлага харуулаад байна. Дотоодын нийт бүтээгдэхүүнийнхээ 10 хувийг ирээдүйн санд нөөцлөдөг Кувейтийн жишиг хараарай. Бяцхан Монголын хувьд ашиг орлого хүримтлуулах цөөхөн боломжийн нэг нь дэлхийн зах зээл дэх үүлэн чөлөөний наран юм. Металлын зах зээлд үнэ ханшийн ийм таатай мөчлөг чамгүй урт хугацаанд үргэлжилж буй болохоор үр

ашгийг нь үүлэн чөлөөний нарана баясах лугаа үрэн таран болгомоогрүү Тэнгэр хангай тэгээд зэвгүйрхэх магадлал ойрхон харагдаж байна. Шинжээдийн үнэлгээгээр 2008 оноос эзэн үнэ унах шинэ мөчлөг эхлэх аж. Энэ сүүдрээс өрсөн Эрсдлийн сан болгоё» хэмээн уриалсан нь хэн хүний бодох асуудал яриангүй мөн.

Л. Болормаа бас Ерөнхий сайд Ц. Элбэгдорж УИХ-ын намрын чуулганы нээлт дээр газрын хэвлэлий дэх баялаг ашиглуулсны үр шимээр Тогтвортжуул хөгжлийн сан байгуулах санал дэвшүүлсэнтэй холбогдуулж өөрийн саналыг нэмэрлэхдээ «Энэ нь дээрхээс арай өөр төрлийн ашиг орлогоос бүрдэнэ гэсэн үг. Хэдий тийм ч дэлхийн улс орнуудад түгээмэл байдаг ирээдүйн болоод хөгжлийн сангудтай зорилго ижил. Гагчхүү сангийн хөрөнгийг боловсролын салбарт зарцуулах нь туйлаас оновчтой. Улс орны тогтвортой хөгжлийн өөр нэг тулах цэг-экологийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилго бүхий хүримтлалын тухай энэ сэдвийн хүрээнд мөн л хөндөх хэрэгтэй буй заа» гэсэн байна.

**Л**■ Болормаа энэ өгүүлэлдээ улс орны эдийн засаг дэлхийн зах зээл, үнэ ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан ихээхэн савалгаатай байгаа нөхцөлд аливаа эрсдлээс хамгаалах сан байгуулах нь зөв боловч тэдгээрийг оновчтой ашиглах нь гол асуудал мөн гэж үзсэн байна. Тогтвортжуул хөгжлийн, ирээдүйн, шатахуны үнийн, махны үнийн гэх мэт олон сан, хүримтлалын сураг гарч байгаа үед хөгжил хийгээд оршин байхуйн гол нөхцөл болсон боловсролын болон экологийн тэнцвэрт байдлыг хадгалах сан байгуулахыг онцлон үзэх санал дэвшүүлсэн нь сэтгүүлч нөхцөл байдлыг гархай ажиж, гол асуудалд эрх

баригчдын анхаарлыг хандуулах үүргээ сайн биелүүлсний гэрч мен. Тэрээр энэ санаагаа лавшуулан «Сайхан санаанууд хэрэв хэрэгждэг бол салбар бүр, засаг захиргааны нэгж болгон цэцэглэн хөгжих нь лавтай. Тэгвэл дээр дурдсан хүримтлалын зарим нь хоосон уутанд зүсэн том хаяг болон хоцорч, нөгөө зарим нь төсвийн орлогоос дундуураа нөхөж байгаа. Нийгмийн даатгалын сангийн 90 хувийг төсөв нуруундаа үүрч явaa жишээ бол хүримтлалыг бурдуулэх эх үүсвэр, эзүүлэн хуваарилах зарчим гажигтай байгаагийн илэрхийлэл» хэмээн анхааруулсан байна.

Л. Болормаа «Хятадын түрлэг» хэмээх улс төрийн прогноздоо сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжлийн замд орсон БНХАУ-ын дэлхийн улс төр, эдийн засгийн тавцанд эзэлж байгаа байр суурийг дүгнэж, цаашидын төлөвийн талаар өөрийн таамаглалыг дэвшүүлсэн байна. Тэрээр юуны өмнө «Бид бусдаас дор гэж үү?!» гэсэн хятад хүн бүрийн дотоод омгорхол нь хөгжил дэвшлийн зүйт тэмүүлсэн Хятадын түрлэгийн хөдөлгөгч хүч боллоо гэсэн санааг илэрхийлж, өнөөгийн Хятад улсын хөгжлийг дэлхийн том гүрнүүд хэрхэн хүлээн авч, ямар стратеги боловсруулж байгааг сөхөн гаргахыг оролджээ. Тэгэхдээ дэлхийн улс гүрнүүд «Хятадын түрлэг»-ийг зохицож, хааж, дагаж хөгжих гурван том бүлэгт хуваагдаад байгааг эрэмбэ дараатай, баримт нотолгоотой өгүүлсэн нь энэ прогноз өгүүллийн цөм санаа болжээ. Эхлээд АНУ, Япон зэрэг тэргүүлэгч гүрнүүдийн бодлогыг шинжилсэн байна. Тухайлбал «АНУ-ын Төрийн департамент Хятадтай хийх худалдааны шинэ бодлого боловсруулж эхлэжээ. Өнөөдөр дэлхийн нийт үйлдвэрлэлийн таван хувь Хятадад, тэгвэл хорь гаруй хувь Америкт ногдож

байгаа. Гэхдээ хол хоцорсон өрсөлдөгч гэж америкууд басамжлахгүй байна. Тавин жилийн дараа тэд биднийг гүйцэх түрүүлнэ гэсэн таамаглалыг АНУ-ын эрдэмтэд хийжээ. Өөрөөр хэлбэл Япон, АНУ хоёр шинэ өрсөлдөгчтэйгээ эдийн засгаа зохицуулж амьдрах нь. Ийм зохицуулалтын зэрэгцээ улс төрийн тавцанд хэл амаа олопцохыг чармайх, цэргийн салбарт чимээгүйхэн өрсөлдөх өдрүүд өмнө иржээ» гэсэн ерөнхий дүгнэлт хийгээд түүнийгээ нарийсган тодруулж «Шинэхэн луугийн хүрхрээн улам ойртох байна. Вальютын нөөцөөр Япон тэргүүлдэг гэв үү? Тэгвэл шил дараад БНХАУ гараад ирлээ. Дэлхийн гурван том экспортлогч хэн болохыг мэдэх үү? АНУ, Германы дараа нөгөө л Хятад шат алхаад жагсчээ. Одоо хүссэн ч, эс хүссэн ч түүний алхаанд зохицож амьдрах үе ирлээ. Бөмбөрцгийн дэлгүүр болгоныг шахам бараагаар хангаж байгаа аварга үйлдвэрлэгч үзэг хэлэх эрхтэй болов» хэмээн бичсэн байна.

**У** даа дараагийн нийтлэлүүдийг нь уншиж байхад Л. Болормаа олж авсан боловсрол, туршлагын хувьд нийгэм-эдийн засгийн томоохон асуудлыг сонгон авч үзэл бодлоо илэрхийлэн, өөрийн санаа, дүгнэлт гаргах хэмжээнд хүрсэн сэтгүүлч болох нь харагдаж байна. Энэ прогнозод л гэхэд «Хятадын түрлэг»-ийг том гүрнүүд төдийгүй дэлхийн бүс нутаг, улс төр, цэрэг, эдийн засгийн бүлэглэлүүд хэрхэн хүлээн авч, ямар стратеги, тактик боловсруулж байгааг нэлээд өргөн далайцтай авч үзсэн байна. Тэрээр «Япон, АНУ-ын өмнө Хятадын эдийн засгатай зохицож амьдрах шаардлага тулгарсан бол Европын холбооны улсууд их түрлэгийг хаах болдого түлхүү барьдаг. Энэ оны зургадугаар сард тус холбоо Хятадаас

оруулах оёмол, сүлжмэл здлэлд хязгаарлалт тавив. Гэвч олон ёнгийн улсыг нэгтгэсэн Европын их булийнхийн дунд Азийн луутай туншилж амьдарсан нь өлзийтэй гэх хандлага мөн сонсогдож байна. Тянь Аньминий хэрэг явдлын дараа Европын холбоо Хятадад зэвсэг нийлүүлэхээ болсон билээ. Тэгэвл хажууд оросууд харсаар байтал зөвсгийн наймаагаар хөлжиж суухад бид хоосон хоцрох нь юу вэ хэмээх уг хэл гарав. Магадгүй Европын холбоо ойрын үед энэ асуудлыг Хятадад нааштайгаар шийдчижэж мэдэх. АНУ, Япон хоёр хичнээн дургүйцээд ч хүчээ аван хүрхрэх луутай ойртох гэсэн эрмэлзэлүүдийг хааж дийлхэгүй бололтой. АНУ-ын дотоодод ч бизнесийнхэн шинэ түншээ илт өмгөөлөх болжээ. Тэр том зах зээлийг алгаараа хаах арга байх биш. Wal Mart-ын сүлжээний дэлгүүрүүд жилд "Made in China" шошготай 18 тэрбум ам. долларын бараа бүтээгдэхүүн борлуулдаг шүү дээ" гэх мэт баримт сэлтийг дурьдаад авсан байна.

**T**эрээр цааш нь бичихдээ «Хятадын алхааг дагаж хөгжих, багалзуурдуулчихалгүй явах бодолтой өөр нэг хэсэг бий. Энэ бүлгийн тэргүүнд ОХУ явна. Өнгөц хараад манай хоёр хөрш бөөр нийлүүлэн хамтарч, АНУ-ын зэрэг цэргийн сургууль хийдэг. Орост хоёр сая гаруй хятад иргэн амьдардаг гэсэн албан бус тооцоо бий. Алс Дорнод бараг хятадуудаар дүүрчээ. Эдийн засгийн хувьд хоёр улс нэг их дорвitoи хамтарч хараахан амжаагүй ч богино хугацаанд «алдаагаа засах» магадлалтай... Хэрэв дөрөвдүгээр сард Японы зэрэг үзэл суртал хүчээ аван эмх замбараагүй байдал олонтаа гарсан шиг явдал давтагдах ахул ОХУ-д айх аюул бий. Хил хязгаар нутгийн газрын

маргаан эргэж сэдрэхээс эмээнэ гэсэн уг. Өмнөдөөс халдвартархан даамжирч, улмаар төв, хойд Хятадад зах зээлийн төдийгүй эрх чөлөөний өргөн мэдрэмжийг түгээж болзошгүй юм. Үндсээрхээ үзлээр хэт хордуулсан энд мэдрэмж хяналтаас хэрэв гарвал хөрш улсууддаа аюулт дохио илгээнэ хэмээн таамагласан байна.

Зохиогч, өмнөд хөршийн аварга алхаа манай улсад хэрхэн нөвлөвөх хийгээд бид ямар бодлого баримталбал зохих талаар ч дуугүй өнгөрсөнгүй. Тухайлбал «Мөнөөх дагаж хөгжихийг чармайгсдын бүсэд монголчууд бас багтаж байна. Монгол улсад орж ирж буй хөрөнгө оруулалт, импорт, экспортын статистикийн тэргүүнд өдгөө өмнөд хөрш баттай байр сууриа зээлжээ. Түүнчлэн төмөрийн хүдэр, зэс, хөнгөн цагааны хэрэглэгээрээ АНУ-ыг аардаа орхисон энэ зах зээлд Монголын хэрэг тун ч их байгаа. Цахилгаан эрчим хүчиний хомсдлоо нөхөхийн тулд Таван толгой, Нарийн сухайт, Цагаан толгойн нүүрсний ордууд руу тэд ханцуй шамлан орж байна. Улмаар Алс Дорнодын хязгаарын махны хэрэглээг хятадууд зүн хувь хангадаг гэдэг шиг монголчудын аливаа эрэлт өмнөд хөршийн атганд багтаж эхлэх шиг санагдана. Дагаж хөгжих нээлттэй бодлого маань ганц зах зээлээс хатуу хамааралтай болох вий гэсэн эмзэглэл монгол хүн бүрт байна.

Ийм эмзэглэлийн зэрэгцээ Хятадын засаг захиргаа өөрөө ч хянаж дийлэх хүч хүрэхгүй байж мэдэх эмх замбарагай жагсаал цуглааны хаялгаас хөрш бяцхан улс эмээн нь ойлгомжтой» хэмээн бичжээ. Тэрээр бас Хятадыг дагаж хөгжих бодлого барьсан орнуудын тоонд Шанхайн хамтын ажилгааны байгууллагын гишүүн орнуудыг нэрлэж, ялангуяа хуучин ЗХУ-ын

бүрэлдэхүүнд багтаж байсан дунд Азийн орнууд АНУ-гаас аажим хөнгийрч Хятадыг дагаж эхэлсэн тухай баримтаар өгүүлсэн байна.

Сэтгүүлч Л. Болормаа улс төрийн прогнозынхао төгсгөл «2010 он гэхэд тэргүүлэх экспортлогч орон болно. Эдийн засгийн өсөлтөөрөө толгой цохино... Урагшаа, дээшээ хөгжин өөдлөх Хятадын алхааг дэлхий баадан, бас эмээн харж байна. Олимп, тивийн урандаан тэмцээнээс хятад тамирчдын хүртэж буй шагналын тоо, чансаатай яг ижил хурдаар эдийн засаг нь тэргүүн байр суурь зээлж эхэллээ. Энэ түрлэгт зохицож, хааж, дагаж хөгжих бодлогууд дэлхийн улстөрчдийн ширээнээ одоо цэгцэрч байна» хэмээн өөрийн гол санааг зангиж өгсөн байна.

Л. Болормаагийн «Даашинзтай сурвалжлагууд» ном түүний уран бүтээлчийн хувьд эрийн цээнд хүрсэн, өөр хэнд ч байхгүй өвөрмөц барил, өнгө аясыг эзэмшсэн сэтгүүлч болохыг нь баталж өгсөн юм. Аливаа юм агуулга, хэлбэр хоёроос бүтдэг. Хүмүүс хэлбэрийг нь эхэлж сонирхоод, түүгээр дамжиж агуулгад нэвтэрдэг. Л. Болормаагийн номын хэлбэр нь сонин шинэлэг, бас донж намбатай болсон юм. Тэр шинэлэг тал нь нэрнээсээ эхэлсэн байв. Ер нь «даашинз» гэдэг үгийн цаана бусгүй хүн төсөөлгөддөг нь зайлбаргүй үнэн. Эдүгээ залуу бусгүйчүүдийн даашины хормойг сөхөж, хөхөвчний цаад руу өнгийдөг эротик сэтгүүл зүйн үе өнгөрсөн. Учир нь охид бусгүйчүүдэд бусдаас нуух юм бараг угий болсон тул сониноос унших шаардлагагүй болсон. Тэгэхээр энэ нэрэнд бусгүйчүүдийг шохоорхо агуулга огт угүй бололтой. Өрнөдийн сэтгүүл зүйд «сонины нугас» гэж үншигчийг чулуу хөөлгөх замаар бичсэн зүйлээ заавал уншуулах занга

тавьдаг нэг арга байдаг. Болормаагийн номын нэр нэг бол түүн шиг номын нугас, мөн хорхой хүргэсэн лид маягийн гарчиг байж болно. Нөгөө талаар улс тэр, бизнесийн хүрээнийхийн булхайг халхалж байдаг хөшгийг даашинзтай зүйрлэж, түүний цаана юу болж байгааг нээж үзүүлэх санаагаа ийнхүү бэлгэдсэн байж ч болох юм. Ямартай ч энэ нэр үншигчийг өөртөө уях увидастай болжээ.

**H**омын зөвхөн нэр нь тэдийгүй, бичвэр нь бас шинэлэг содон юм. Уран гоё үг, өгүүлбэр ургаж, өнгө будгаар чимээд байгаагүй хэрээ уг бүр нь байраа олж, байгаа оносон байдагт л түүний ур чадварын нууц оршиж байх шиг. Юмны үзэгдэх талыг биш, мөн чанарыг онцлогдог, үгийг сонгоходоо “долоо хэмжиж нэг отолдог” няят нямбай чанар нь түүний түүрвилын ханшийг өсгедэг байна.

Л. Болормааг Монголын шинэ сэтгүүл зүйн сонини менежментэд шинэчлэл хийсэн сэтгүүлч гэж хэлэхэд хэтрүүлсэн болохгүй биз. Тэрбээр «Америкт “хулгай” хийж явна» гэсэн гарчигтай авсаархан нийтлэлдээ «Эндхийн өдөр тутмын сонинуудын гал тогоо руу өнгийж олж мэдсэнээ тэмдэглэсээр явтал олон далбагар дэвтэр дүүрчээ» гэж бичсэн байсан. Түүгээрээ ном бүтээснийг нь ч харсан. Гэтэл саяхан бас «Завгүй» гэдэг нэртэй ном нь гараад ирлээ. Чухам л сонини менежерүүдийн өдөр тутам сөхөж байвал зохих ширээний ном болжээ. Ёстой л негөө Америкаас хулгайлж ирсэн хэдэн дэвтэр үүцээ задалсан бололтой. Ном хийц хэлбэрээрээ ч, бүтэц агуулгаараа ч америк донж маягаар бүтээгдсэн байна. Хамгийн чухал нь сонин ямар байх ёстой, эрхлэгч, менежерүүд хэрхэн ажиллаж, юунд гол анхаарлаа хандуулах

учиртай амьдралын жишээгээр нэн ойлгомжтой илэрхийлсэнд оршино. Гаднын туршлага, өөрийн дадал хоёрыг эвцэлдүүлж цогцлоосон мэдлэгтээ тулгуурлан «Өнөөдөр» сониньг өглөө бүр унших хэрэгцээг бүй болгох төсөл» боловсруулж хэрэгжүүлсэн нь бусад сонинуудад менежментээ хэрхэн сайжруулахын үлгэр загвар болсон юм. Уншигчдын дунд олон асуулт бүхий тандалт судалгаа явуулж, эрэлт хэрэгцээг сайн судалсны үндсэн дээр сонинихоо бодлого, үйл ажиллагааг тодорхойлсон нь төслийг үр дүнтэй болгох нөхцөл болсныг тэмдэглүүштэй. Америкийн туршлагыг хэрхэн идээшүүлж, үндэсний онцлогтойго хэрхэн хослуулж, «Өнөөдөр» сонины менежментийг яаж сайжруулсан арга технологи Л. Болормаагийн «Завгүй» номонд тодорхой туссан байна.

Л. Болормаа сонинихоо үр нөлөөг сайжруулах төслийг өөрийн боловсруулсан судалгааны хариунд тулгуурлан зохиосон нь үр дүнгээ өгчээ. Сонины менежментийн цөм нь нийтлэлийн чанарыг сайжруулах замаар уншигчдынхаа хүрэг өргөтгөх явдал мөн. Тэгвэл уншигчид юу хүсч байна, юу хийвэл дээр вэ гэдгийг мэдэх хэрэгтэй. Боломаа яг л ингэж ажилласан байна. Тэгэхдээ сэтгүүл зүй өндер хөгжсөн Америкийн туршлага, судалгааны дүнг өргөн ашигласан юм. Жишээ нь «Вашингтон пост» сонины эрхлэгч Майк Шепард уншигчид сонинь нэг дугаарт зориулах цагийнхаа 75 хувийг зөвхөн фото зургуудад зарцуулдгүй судалж тогтоосонтой Болормаагийн тандалт таарч байжээ. Энэ нь сонинд орох фото зургийг олшируулж, хэмжээг томруулах, зургийг аль болохоор бие даасан нийтлэлийн агуулга, өгүүлээмжтэй байлгах хэрэгтэй юм байна гэсэн шийдвэр гаргахад хүрчээ.

Түүнчилэн Монголын өдөр тутмын сонинуудын реклам, зарын менежерүүд хамтарч хэвлэл мэдээллийн заалзэлийн нэгдсэн судалгаа хийх цаг болсныг анхааруулаад Улаанбаатар хотын дүүрэг, гудамж, бичил хорооллууд дахь аж ахуйн нэгж, компанийн үйлдвэр үйлчилгээний газруудын байршилын зураглалтай болж, аль хэсэгт нь хэдий үед зар сурталчилгааны хэрэгцээ өсч байгааг харгалзан ажлаа зохицуулах, зар сурталчилгаа, редакцийн үйл ажиллагаа ямарг тусдаа байх зэрэг амьдралаар батлагдсан чухал зөвлөмжүүд энэ номын агуултыг бүрдүүлж байна.

**Е**р нь Л. Болормааг онолын мэдлэг, ажлын арга барил, бусдын туршлагыг тэгш цопцлуулсан морьтой сэтгүүл хэмээн нэрлэж болох мэт. Тэр бүхний эх үндэс нь үндэснийхээ уламжлалыг өрнөдийн туршлагаар сэлбэж нэгэн их хэв арга барил болгож чадсанд орших байна.

### Ишлэл

<sup>1</sup> Болормаа Л. 2007. Даашинзтай сурвалжлагууд. УБ., 76 дахь тал.

<sup>2</sup> Норовсүрэн Л. 2007. Монголын нийтлэл. Гутгаар боть. УБ., 354 дахь тал.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болормаа Л. 2007. Даашинзтай сурвалжлагууд. УБ.

2. Болормаа Л. 2013. Завгүй. УБ.

3. Баасансүрэн Т. 2009. 1990 оны ардчилсан хувьсгал ба Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил, түүний цаашдын төлөв. УБ.

4. Зулькафиль М. 1999. Сэтгүүл зүйн онолын үндэс. Тэргүүн дэвтэр. УБ.

5. Норовсүрэн Л. 2007. Монголын нийтлэл. Гутгаар боть. УБ.

6. Норовсүрэн Л. 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. УБ.

### Summary

This article also states the publication specification, management and writing skills

of journalist L.Bolormaa. L.Bolormaa is a young leader and talented publicist, as well as she succeeded in incorporating Western experiences to the journalism.